

Богд банк ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ
/2022.12.30-ний байдлаар. /

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9.6		96
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5.4		90
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		67
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75
8	Компанийн соёл	6	5.4		90
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9.5		95
	Нэгдсэн дүн	72	65		90

Үнэлгээний аргачлал

1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.
2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:
 - 2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
 - 2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
 - 2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
 - 2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биецүүлсэн эсэх, биецүүлээгүй бол яагаад биецүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Эдгээр албан тушаалтны хариуцах ажлын чиг үүрэг, хариуцлагыг ТУЗ-ийн ажиллах журамд хариуцах ажлынх нь төрлөөр ангилан нэлээд дэлгэрэнгүй тусгасан.	2	100
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, төмилхө асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 12-р сарын хурлаар ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх Удирдлагын залгамж халааны бодлого, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох чөлөөлөх журам зэргийг баглан гаргаж нийтэд нээлттэй болгох зорилгоор компанийн цахим хуудаст тавьсан болно	2	100
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсанд авч байршуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлж байгаа.	Мэдээллийг вэб сайт болон тайланд тусган ажиллаж болно.	2	100
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүний ур чадварын матриц, түүнийг тодорхойлох журам болон Хороодын ажиллах журмыг хороо бүрээр шинээр тусгайлсан боловсруулж ТУЗ-өөр батлуулан гаргаж компанийн цахим хуудас тавьсан ба тэдгээрт гишүүдийг сонгох,чөлөөлөх болон гишүүдийн эрх, үүргийг тусгаснаас гадна хороо бүрийн чиг үүрэг, хорооны хурлыг хуралдуулах журам зэргийг тусгасан болно.	2	100
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх төмилөгдөхөд чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Уг асуудлыг ТУЗ-ийн ажиллах журмын гуравдугаар бүлэгт ТУЗ-ийн шинэ гишүүнтэй ажиллах ажилалгаа, гишүүний ур чадварыг дээшлүүлэх гэсэн тусгай бүлэг болгон оруулсан болно.	2	100
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээн.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ийн НБД-ийн томилгоо болон үйл ажиллагааг түүний хэрэгжүүлэх ёстой ажлынх нь төрлөөр ангилан ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгайлан зааж өгсөн болно	2	100
ДҮН				12	100

ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хуульд заасны дагуу хэрэгжсэн.	Цаашид энэ асуулганд заасны дагуу болгохоор ажиллаж байгаа.	1.6	80
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжсэн	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн хэрэгжүүлдэг. Аудитын хорооны үйл ажиллагааны тусгайлсан журмыг ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын хурлаас батлан гаргаж компанийн цахим хуудаст тавьсан болно	2	100
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжсэн	Цалин урамшууллын хорооны даргын албан тушаалыг хараат бус гишүүн хэрэгжүүлдэг. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын хурлаас батлан гаргаж компанийн цахим хуудаст тавьсан болно	2	100
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжсэн	Нэр дэвшүүлэх хорооны даргын албан тушаалыг хараат бус гишүүн хэрэгжүүлдэг. тус хорооны ажиллах журмыг ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын хурлаас батлан гаргаж компанийн цахим хуудаст тавьсан болно	2	100
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжсэн	Манай компани хуульд заавал байхаар заасан 3 хороотойгоос гадна байнгын ажиллагаатай эрсдэлийн хороог байгуулан ажиллуулдаг. Мөн шаардлагатай тохиолдолд байнгын болон түр хороог байгуулж болох болон хорооны гишүүдэд тавих шаардлагыг холбогдох журамд нь тусган ажиллаж байгаа болно	2	100
ДҮН				9.6	96

ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Хэрэгжүүлж байгаа	Компанийн мэдээллийн бодлогын тусгайлсан журмыг шинээр боловсруулан ТУЗ-ийн 12-р сарын хурлаар батлан гаргаж компанийн цахим хуудаст тавьсан ба түүндээ компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой нээлттэй байх мэдээллийн жагсаалтыг хэрхэн нээлттэй бологох журмын хамт тусгасан болно. Цаашид тэдгээр мэдээллийг нээлттэй болгох ажлыг цаг тухайд хэрэгжүүлэх болно.	1.7	85
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа	Кодекст заасан 25 дүрэм, журмуудаас 15 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж ТУЗ-өөр батлуулан компанийн цахим хуудаст нээлттэйгээр тавьсан ба цаашид үлдсэн журмуудыг кодекст заасан зарчмуудтай уялдуулан дахин авч үзэх болно.	1.7	85
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна	Банк нь Монголын Банкны холбооны дэргэдэх Тос Холбоонд холбогдох тайлангаа хагас жил тутам хүргүүлж ажиллаж байна. Жил бүр ажлын хэсэг байгуулан төсөв төлөвлөгөөгөө батлан зорилт зорилгоо тодорхойлон хэрэгжүүлдэг бөгөөд үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	2	100
ДҮН				5.4	90.00%

ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны ажиллах журмын аудитын хорооны чиг үүрэгт хөндлөнгийн болон дотоод аудитын нэгжтэй харьцах асуудлыг кодексет заасан заалтын хүрээнд авч үзсэн болно.	2	100
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Хагас хэрэгжилттэй	Энэ асуултанд заасан асуудлыг ХЭХ-ын журмын төсөлд тусгасан бөгөөд үү журмыг ТУЗ-ийн дараагийн хуралд оруулж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна	1	50
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан журамтай. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг.	2	100
ДҮН				5	84

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон компайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжиж байгаа	Банкны үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд эрсдэлийн удирдлагад Банкны ТУЗ чухал ач холдогдол өгч ажилладаг. Мөн Гүйцэтгэх удирдлагын түвшинд өдөр тутмын болон богино, дунд хугацааны эрсдэлийг хянах, удирдах чиг үүрэг бүхий нэгж, Гүйцэтгэх захирал холбогдох мэргэжлийн газар нэгжийн захирлуудаас бүрдсэн Эрсдэлийн Удирдлагын Хороо ажилладаг. Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газар нь өөрийн чиг үүргийн хүрээнд зээл, зах зээл, комплансе, үйл ажиллагаа, хууль эрх зүй, мэдээллийн аюулгүй байдлын болон нэр хүнд, стратегийн эрсдэлүүд зэрэг олон талын эрсдэлүүдийг олон улсын шилдэг туршлагын дагуу эрсдэлээс хамгаалах гурван шугамыг идэвхжүүлж, эрсдэлд суурилсан хандлага үнэлгээний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-аас банкны Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын бодлого, Байгаль орчин нийгмийн хөгжил, жендерийн тэнцвэртэй байдлын бодлого, зэрэг бодлого журмуудыг баталж, Банкны жил бүрийн Эрсдэлийн аппетитыг тогтоож, түүний гүйцэтгэлд улирал тутам хяналт тавьж ТУЗ-ийн ЭУХ-оор хэлэлцдэг.	2	100
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлаглана.</i>	Бүрэн хэрэгжиж байгаа	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хувьд Эрсдэлийн удирдлагын 2 хороо байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр даргалуулсан тусгайлан чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын хороо ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагааг хороодын ажиллах нэгдсэн журмаар зохицуулдаг. Компани нь ТУЗ-ийнхээ дэргэд эрсдэлийн удирдлагын хороо ажилладаг бөгөөд түүний үйл ажиллагааг хороодын ажиллах нэгдсэн журмаар зохицуулдаг. Эрсдэлийн Удирдлагын Хорооны ажлын тайланг улирал тутамд Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд тайлагнаж байгаа.	2	100
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Бүрэн хэрэгжиж байгаа	Банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг хянах удардах талаар тусгайлан бодлого журам гарган хэрэгжүүлж байгаа. Эдгээр бодлого, журмын дагуу Банк ямар төрлийн бизнес, үйл ажиллагаанд санхүүжилт олгох, эс олгох бодлого журмаа вебсайтаараа олон нийтэд нээлттэй мэдээлдэг. Түүнчлэн банк жижиг дунд бизнес, эмэгтэйчүүдийн эрхэлж байгаа бизнес, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй автомшин зэрэг хэрэглээг бодлого журмаараа тусгайлан авч үзэж тааламжтай нөхцөл олгодог. Энэ талаар банкны вебсайтад нээлттэй мэдээлдэг.	2	100
21	<i>5.4. Компани нь компайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжиж байгаа	Банк нь Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газрынхаа бүтэцд Компайнсын хэлтэстэй бөгөөд уг хэлтэс өөрийн үйл ажиллагааны журмууд болон Мөнгө угаалт терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх, харилцагчаа таньж мэдэх талаарх НҮБ, ОПАК, ЕХ зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, журам, санкцууд зэргийг мөрдөж үйл ажиллагаагаа явуулдаг.	2	100
ДҮН				8	100

ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсвийг жил бүр ХЭЭХ-аар хэлэлцэн батладаг бөгөөд ТУЗ-ийн ажиллах журамд гишүүдэд олгох цалин урамшууллын хэмжээ, хэлбэрийг дэлгэрэнгүй заасан болно	2	100
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжиж байгаа	Одоо компанийн хэмжээнд эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын асуудлыг ТУЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашдаа энэ асуулгад заасан асуудлыг тухайн ажилтны асуудлыг тусгасан бодлогын баримт бичигт тусгах ажлыг эхлүүлээд байна.	1	50
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлдэг	Цаашид энэхүү асуулгад заасан асуултыг тусгасан журам боловсруулахаар ажиллаж байгаа болно	1	50
ДҮН				4	66

ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
25	<i>7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжсэн	Оролцогч талуудтай харьцах тусгайлсан бодлогын баримт бичгийг боловсруулан 2022 оны 12-р сард батлан гаргаж компанийн цахим хуудаст байршуулсан бөгөөд түүнд оролцогч бүх талуудтай хэрхэн харьцах харилцааг тусгасан болно.	2	100
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Хэрэгжүүлж эхэлж байгаа	Дээр дурдсан бодлогын баримт бичигт оролцогч нартай хэрхэн харьцах асуудлыг нэг бүрчлэн авч үзсэн. Цаашид энэхүү баримт бичигт тусгасан харилцааны хэрэгжилтийг жил бүрийн тайлан тусган хэрэгжүүлэх болно	1	50
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Хэрэгжүүлж эхэлж байгаа	Цаашид оролцогч нартай харилцаж байгаа байдлын талаараа тухайн бүр нь нийтэд цахим хуудсаараа дамжуулан мэдээлж байх болно	1	50
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Бүрэн хэрэгждэг	Компанийн Хөдөлмөрийн дотоод дүрэм журмын дагуу компаний ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг нээлттэй хүлээн авч шийдвэрлэдэг мөн ажилтнуудыг нийгмийн асуудалд байнгын анхаарал хандуулж хариуцлагатай хандан шийддэг болно. Ажилтнууд өөрсдийгөө хөгжүүлэх ,мэргэжил дээшлүүлэх, хөгжихөд зориулж жил болгон сургалтын төлөвлөгөөгөө батлуулж ажилдаг болно.	2	100
ДҮН				6	85

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлж байгаа	Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, банкны цахим хуудаст нээлттэй байршуулсан байдаг. Мөн Ёс зүйн дүрмийг 2015 онд батлан түүнийг банкны ажилтан бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ нь Дотоод аудитын газраараа дамжуулан тус дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьдаг.	2	100
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.</i>	Бүрэн хэрэгжүүлж байгаа	Богд банкны Ёс зүйн дүрэмд ажилтан бүр шүгэл үлээгчийн үүрэгтэй байх талаар тусгасан ба зөрчлийг мэдээлэх суваг, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байгаа. Мөн 2022 онд "Богд банкны залилангийн эсрэг баримтлах бодлого"-ыг ТУЗ-оор батлуулсан. Тус бодлогод шүгэл үлээх тогтолцооны талаар тусгасан байдаг	2	100
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Хэрэгжүүлж эхэлсэн	Энэ талаар ТУЗ-ийн гишүүдийн хувьд түүний журмын шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Бусад ажиллагчдын хувьд төстэй заалтууд зарим журманд бий.	1.4	70
ДҮН				5.4	83/90

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	хэрэгжүүлж эхэлсэн	Компанийн цахим хуудаст санхүүгийн болон үйл ажиллагааны жилний тайлан, бүтэц зохион байгуулалтын мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулдаг.	2	100
33	<i>9.2. Компани хоронго оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сүвгийг хөгжүүлнэ.</i>	Бүрэн хэрэгжиж байгаа	ХЭ-тэй харьцах тусгайлсан журмыг боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулан цахим хуудандаа тавьсан бөгөөд тус журамд ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэхэд нь компани хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой тусгасан	2	100
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>	Хэрэгжүүлдэг	Дээрх журамд энэ асуудлыг тодорхой тусгаснаас гадна Хуульд заасны дагуу хурлын саналыг авдаг ба хурлыг зохион байгуулдаг.	2	100
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа	Хууль болон дүрэм журмыг дагаж мөрдөн ажиллагаагаас гадна ХЭХ-ын саналын хуудаст энэ асуудлыг бүрэн тусгах замаар хэрэгжүүлдэг	1.5	75
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэцээл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Шинээр СЗХ хийх тусгайлсан журмыг боловсруулан ТУЗ-оор батлуулсан ба энэхүү журмаа компанийн цахим хуудаст тавьсан болно	2	100
ДҮН				9.5	95
НӨГДСЭН ДҮН					